



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 03 дугаар сарын 16
№11 (1406)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

36.	“Цахимаар нэн тэргүүнд” бодлогын зөвлөмж батлах тухай	Дугаар 108	627
37.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 117	637

626

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 09 дүгээр
сарын 24-ний өдөр

Дугаар 108

Улаанбаатар
хот

“Цахимаар нэн тэргүүнд” бодлогын зөвлөмж батлах тухай

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 5.3 дахь зорилт, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.2, 4.3 дахь хэсэгт заасан зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор “Цахимаар нэн тэргүүнд бодлогын зөвлөмж”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Цахимаар нэн тэргүүнд бодлогын зөвлөмжийг бүх шатны төрийн байгууллагад сурталчлан таниулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан, тайлан, мэдээллийг нэгтгэн жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал нарт даалгасугай.

3.Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Г.ЗАНДАНШАТАР

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД**

Э.БАТШУГАР

Засгийн газрын 2025 оны 09 дүгээр
сарын 24-ний өдрийн 108 дугаар
тогтоолын хавсралт

“ЦАХИМААР НЭН ТЭРГҮҮНД (DIGITAL FIRST)” БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Нэг.Ерөнхий зүйл

1.1.“Цахимаар нэн тэргүүнд (Digital First)” бодлогын зөвлөмж нь хүн төвтэй үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр нэн тэргүүнд санал болгож, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, өгөгдөлд суурилсан бодлого, шийдвэр гаргалтыг төлөвшүүлэх, хувийн хэвшлийн цахим инновацыг дэмжих замаар улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд баримтлах зарчим болно.

1.2.Энэхүү бодлогын зөвлөмж нь Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын зорилт 5.3.(Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ), зорилт 7.5.(Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно), Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилт 6.1.(Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна), Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.2.(Дэвшилтэт технологид суурилсан цахим засаглал), 4.3.(Цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл)-т заасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд баримтлах баримт бичиг мөн.

Хоёр.Баримтлах зарчим

2.1.Хүн төвтэй үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр нэн тэргүүнд санал болгож, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, өгөгдөлд суурилсан бодлого, шийдвэр гаргалтыг төлөвшүүлэх, хувийн хэвшлийн цахим инновацыг дэмжих замаар улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд дараах зарчмыг баримтална.

2.1.1.Хүн төвтэй, үйлчилгээ нь хялбар, хүртээмжтэй байх:

2.1.1.1.аливаа үйлчилгээг цахим хэлбэрээр загварчлахдаа хэрэглэгч (иргэн, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, байнгын оршин суугаа гадаад иргэд)-ийн хэрэгцээ, хүсэл, оролцоонд тулгуурлан зохион байгуулна;



2.1.1.2.хэрэглэгчийн туршлага (User Experience-UX), хэрэглэгчийн интерфейс (User Interface-UI) нь хэрэглэхэд хялбар, ойлгомжтой, хүртээмжтэй (олон төхөөрөмж ашиглах боломжтой) байна;

2.1.1.3.үйлчилгээ нь олон хэл (монгол, англи) дээр, төлбөрийн аливаа хэлбэр бүхий сонголттой байх бөгөөд орон зай, цаг хугацаанаас үл хамаарч авах боломжтой байна;

2.1.1.4.хэрэглэгчээс үйл ажиллагаа болон үйлчилгээний чанар (шат дамжлага, хялбар байдал), хүртээмжид санал, үнэлгээ өгөх сувагтай байна;

2.1.1.5.төрийн цахим үйлчилгээг хиймэл оюунд суурилсан төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia)-д бүрэн холбож, хэрэглэгч дуу, дүрс, дуу-дүрсийн хосолсон оролцоогоор үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ;

2.1.1.6.үйлчилгээг хэрэглэгчийн ялгаатай байдал (нас, байршил, хөгжлийн бэрхшээл, хэл г.м)-аас үл хамаарч эрх тэгш авах боломжийг бүрдүүлнэ;

2.1.1.7.цахим орчинд иргэний эрх зүйн байдлыг тодорхойлж, цахим оролцоог зохицуулсан “Цахим иргэн”-ий тухай эрх зүйн орчныг бүрдүүлнэ;

2.1.1.8.иргэн хуулийн этгээдийн цахим хувийн хэрэг (Digital Profile)-ийг үүсгэнэ;

2.1.1.9.төрийн бодлогыг боловсруулахдаа иргэдийн санал, дэмжлэг, шүүмжлэл хүлээн авдаг нэгдсэн системийг ашиглана;

2.1.1.10.төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавих зэрэгт иргэд болон хуулийн этгээд оролцох боломжийг бүрдүүлсэн системтэй байна. Цахимаар санхүүгийн тайлантай танилцах, төлсөн татварын зарцуулалтыг хянах эрхтэй байх;

2.1.1.11.иргэний амьдралын үйл явцад суурилсан үйлчилгээг төрөлд нь ангилах бус, харин иргэний амьдралын чухал үе шатуудад (жишээ нь, хүүхэд төрөх, гэрлэх, шинэ бизнес эхлүүлэх) тохирсон цогц багц үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлэх;

2.1.1.12.иргэд, хуулийн этгээдэд зориулсан төрийн үйлчилгээний төлбөрийг нэгдсэн гарц ашиглан төрийн санд шууд төвлөрүүлж, төлбөр төвлөрүүлэх сувгийн тоог нэмэгдүүлэх.

2.1.2.Бүх төрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхийг үндсэн хэлбэр болгох:

2.1.2.1.иргэн, хуулийн этгээдийн тухай мэдээлэл хариуцагч өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байна;

2.1.2.2.мэдээллийн системийг дахин загварчлах, хамтран ашиглах боломжтой байх бөгөөд техник технологийн харилцан үйлчлэлийг оролцогч талуудтай урьдчилан тохиролцсон байна;

2.1.2.3.мэдээллийн системийг шинээр үүсгэх, өөрчлөх, шинэчлэхдээ амьдралын мөчлөгийн аргачлал (life-cycle approach)-ыг бүрэн цахим байхаар боловсруулж, хэрэгжүүлнэ;

2.1.2.4.төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг бодит цагийн горимоор солилцох өгөгдөл нь зөвшөөрөгдсөн этгээдэд хандах боломжтой, стандарт, хууль, эрх зүйн шаардлагад нийцсэн, тухай бүр шинэчилсэн, бүрэн аюулгүй, найдвартай, эх сурвалж нь тодорхой байна;

2.1.2.5.иргэнд зориулсан цахим үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia)-д, хуулийн этгээдэд зориулсан үйлчилгээг “e-Business” платформд нэгтгэж, иргэд, хуулийн этгээдтэй харилцдаг ажилтны тоог бууруулна;

2.1.2.6.бүх шатны төрийн байгууллагын үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхэд Төрийн цахим үйлчилгээний стандартыг баталж, мөрдөнө;

2.1.2.7.төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхэд үйл ажиллагааны дахин инженерчлэлийг салбар бүрд нэвтрүүлж, төрийн үйлчилгээний 90 хувийг цахим хэлбэрт шилжүүлнэ;

2.1.2.8.үйл ажиллагаа, үйлчилгээнд хиймэл оюуныг ашиглана;

2.1.2.9.бүх шатны төрийн байгууллага албан хэрэг хөтлөлтийн систем ашиглах бөгөөд албан бичиг солилцооны дундын системд холбогдсон байна;

2.1.2.10.төрийн албаны үйл ажиллагаанд тоон гарын үсгийг баталгаажуулалтын үндсэн хэлбэр болгоно;



2.1.2.11.цахим орчинд иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн албан тушаалтныг танихдаа арга хэрэгсэл, аюулгүй байдал, стандартын шаардлага хангасан танилт нэвтрэлтийн систем ашиглана;

2.1.2.12.бүх шатны төрийн байгууллагын (захирамжлалын) шийдвэр, үүрэг даалгавар, тайлангийн анхдагч хэлбэр нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах цахим хэлбэртэй байна.

2.1.3.Өгөгдөл солилцооны нэгдсэн стандарт, аргачлалтай байх:

2.1.3.1.аливаа өгөгдөл бодит цагийн чанартай байх бөгөөд өгөгдөлд үндэслэж төлөвлөлт, шийдвэр гаргана;

2.1.3.2.өгөгдлийг нэг удаа цуглуулж (data-once-only), нэг эх сурвалжаас үнэн зөв мэдээлэл (single-source-of-truth, SSoT) авдаг байна;

2.1.3.3.өгөгдлийг үүлэн технологид бүрэн шилжүүлнэ;

2.1.3.4.мэдээлэл хариуцагч байгууллагууд төрийн их өгөгдлийн санд өгөгдлөө нийлүүлнэ;

2.1.3.5.өгөгдөл солилцооны нэгдсэн платформ иргэн, хуулийн этгээд (төрийн болон хувийн хэвшил) тэгш, хүртээмжтэй ашиглана;

2.1.3.6.хиймэл оюун болон өгөгдөл солилцох эрх зүйн орчныг бүрдүүлнэ;

2.1.3.7.хиймэл оюун болон өгөгдөл солилцооны нэгдсэн стандарт, аргачлалыг боловсруулж, бүх шатны төрийн байгууллагад мөрдүүлнэ;

2.1.3.8.өгөгдөл цуглуулах, боловсруулах, ашиглах, хиймэл оюуны GPU кластерыг дата төвүүдэд үүсгэнэ;

2.1.3.9.өгөгдөл цуглуулах, боловсруулах, ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах дэд бүтэц бүхий үндэсний их өгөгдлийн нэгдсэн сан байгуулна;

2.1.3.10.“Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, нэгдсэн мэдээлэл, хяналтын дашбоард систем”-ийг өргөжүүлэх, бүх шатны төрийн байгууллагуудад нэвтрүүлэх;

2.1.3.11.өгөгдөл ашиглалт, хиймэл оюуны хэрэглээнд ёс зүйн хяналт (Artificial Intelligence ethic)-ыг хэрэгжүүлнэ;

2.1.3.12.өгөгдлийг программ хангамжийн интерфэйс болон их өгөгдөл хиймэл оюуны технологи ашиглах боломжтойгоор боловсруулж, хадгалах бөгөөд бодит цагийн мэдээлэл дээр үндэслэн, урьдчилан таамаглах системтэй байна;

2.1.3.13.их өгөгдөл, өгөгдөл боловсруулах, хадгалах, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн орчинтой байна.

2.1.4.Кибер аюулгүй байдлыг хангасан байх:

2.1.4.1.иргэн, хуулийн этгээд хувь хүний мэдээллийг ашиглахдаа мэдээллийн эзнээс зөвшөөрөл авдаг байна;

2.1.4.2.үүлэн технологид суурилсан тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлж, олон улсад итгэмжлүүлнэ;

2.1.4.3.цахим оролцоог хангасан гамшиг, онцгой байдалд хариу арга хэмжээ авах, сэргээх үйл ажиллагаанд зориулсан тусгай стратегитай байна;

2.1.4.4.төрийн байгууллагын кибер аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог сайжруулж, эрсдэлийг урьдчилан тооцох, мэдээлэл хамгаалах нэгдсэн стандарт, шаардлагыг тогтооно;

2.1.4.5.кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдалд хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ;

2.1.4.6.кибер халдлага, зөрчлийг мэдээлэх, бүртгэх, солилцох дэд бүтэцтэй байна;

2.1.4.7.технологийн хэрэглээнээс үүдэн гарах эмзэг байдал, аюул заналыг таних, эрсдэлийг бууруулах, халдлага, зөрчилтэй тэмцэхэд дэвшилтэт технологийг ашиглана;

2.1.4.8.мэдээлэл, харилцаа холбооны техник хэрэгсэл, программ хангамж, электрон төхөөрөмжийн үндэсний үйлдвэрлэл, инновац, судалгаа, шинжилгээний хөгжүүлэлтийг дэмжиж, технологийн хараат байдлыг бууруулна;

2.1.4.9.мэдээллийн аюулгүй байдлын стандартуудыг нэвтрүүлэх, хяналтыг хэрэгжүүлнэ;



2.1.4.10.үзүүлж байгаа үйлчилгээний онцлогт тохируулж, мэдээллийн аюулгүй байдлын болон нууцлалын бодлоготой байна;

2.1.4.11.шинэ (хиймэл оюун, робот, блокчен, 5G, IoT, дрон, сансрын технологи г.м) болон шинээр гарах дараа үеийн технологийг турших, нэвтрүүлэх, ашиглахтай холбоотой хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2.1.5.Бүх нийтийн цахим ур чадвар, оролцоог нэмэгдүүлсэн байх:

2.1.5.1.зорилтот бүлэгт чиглэсэн цахим ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, цахим орчинд тэгш, хүртээмжтэй оролцох боломжийг бүрдүүлнэ;

2.1.5.2.төрийн албан хаагчийн цахим ур чадварыг сайжруулах хөтөлбөрийг боловсруулж, үе шаттай хэрэгжүүлнэ;

2.1.5.3.төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, боловсролын байгууллагын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурлан цахим ур чадварын сургалтыг зохион байгуулна;

2.1.5.4.насан туршийн боловсролыг дэмжих нээлттэй цахим сургалтын платформыг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлнэ;

2.1.5.5.технологийн дотоодын болон олон улсын тэргүүлэх байгууллагын сертификаттай мэргэжилтэн бэлтгэж, салбарт нарийн мэргэшлийн хүний нөөцийг нэмэгдүүлнэ;

2.1.5.6.төрийн бүх шатны байгууллага мэдээллийн технологийн бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх, мэдээллийн болон кибер аюулгүй байдлыг хангаж, их өгөгдөл, хиймэл оюун (AI) ашиглах үйл ажиллагааг мэдээллийн технологийн чиглэлийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод тусгасан байна;

2.1.5.7.ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангиас мэдээлэл технологи, STEM, хиймэл оюуны хөтөлбөрийг боловсруулж нэвтрүүлэх, цахим боловсролын тогтоолцоог төлөвшүүлнэ.

2.1.6.Төр хэрэглэгч болон хувийн хэвшлийн байгууллагатай өрсөлдөхгүй байх:

2.1.6.1.төр хууль, журамд тусгайлан зааснаас бусад мэдээллийн систем, программ хангамжийг хөгжүүлэхгүй, үйлчилгээний зориулалттай тоног төхөөрөмж (киоск машин г.м) суурилуулахгүй бөгөөд

хувийн хэвшлийн хөгжүүлсэн мэдээллийн систем, программ хангамж, тоног төхөөрөмжийг ашиглахыг үндсэн хэлбэр болгоно;

2.1.6.2.хувийн хэвшлийн санаачилга, төрийн үйлчилгээний аутсорсингийг дэмжиж, бүтээмжийг нэмэгдүүлнэ;

2.1.6.3.төсөл, хөтөлбөрийг хувийн хэвшилд шилжүүлэх, төрөөс хэрэгжүүлж байсан зарим төсөл, үйл ажиллагааны нууцлал аюулгүй байдлыг хангаж, хувийн хэвшлийн байгууллагуудад гэрээгээр шилжүүлэн өгөх;

2.1.6.4.оюуны өмч, патент олгох тогтолцоог олон улсын түвшинд хүргэнэ;

2.1.6.5.энэ зөвлөмжийн 2.1.6.1-2.1.6.3 дахь дэд заалтыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагууд зардал гаргахгүйгээр, төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмыг нэн тэргүүнд баримтална.

2.1.7.Хүртээмжтэй, тасралтгүй, найдвартай дэд бүтэцтэй байх:

2.1.7.1.ухаалаг хот шийдлийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжид нэвтрүүлнэ;

2.1.7.2.төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд харилцаа холбооны сүлжээ хүрээгүй орон нутгийн нэгжийг холбоно;

2.1.7.3.хот, суурин газар, хилийн боомтуудыг орчин үеийн 5G сүлжээгээр тасралтгүй хангана;

2.1.7.4.орон нутгийн интернэтийн урсгалыг нэмэгдүүлнэ;

2.1.7.5.үндэсний хиймэл дагуулын сүлжээ ашиглан цахим дэд бүтцийг бий болгож, хүртээмжийг нэмэгдүүлнэ;

2.1.7.6.харилцаа холбооны сүлжээний төлөвлөлтийг бусад инженерийн шугам сүлжээтэй уялдуулж, цахим үйлчилгээний тасралтгүй, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлнэ;

2.1.7.7.шуудангийн илгээмжийг ангилан боловсруулахад болон хүргэлтийн үйл ажиллагаанд робот, дрон, хиймэл оюуны технологийг ашиглана;



2.1.7.8.өргөн нэвтрүүлгийн тоон технологийг нэвтрүүлнэ;

2.1.7.9.хаягийн нэгдсэн системийг нэвтрүүлнэ;

2.1.7.10.хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон хөгжлийг дэмжсэн стратегитай байна;

2.1.7.11.харилцаа холбоо, мэдээллийн технологийг турших туршилтын орчин (sandbox)-той байна.

Гурав.Бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, хөрөнгө оруулалт

3.1.“Цахимаар нэн тэргүүнд (Digital first)” бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах Ажлын хэсгийг Ерөнхий сайдын дэргэд, нэгдсэн төлөвлөгөөг салбар бүрийн уялдааг ханган хэрэгжүүлэх Ажлын дэд хэсгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд тус тус байгуулна.

3.2.Бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө болон бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт (KPI)-ийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3.3.Засгийн газрын бүх шатны байгууллага энэхүү бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган, холбогдох тайлан, мэдээллийг хагас жил тутам цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.4.Бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсөв, хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл, буцалтгүй тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт байна.

---оОо---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 10 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 117

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакирт даалгасугай.

4. Энэ тогтоолыг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Г.ЗАНДАНШАТАР

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД**

Т.АУБАКИР

[illegible]

Засгийн газрын 2025 оны 10 дугаар
сарын 01-ний өдрийн 117 дугаар
тогтоолын хавсралт

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-26.1.6 дахь заалтад заасан тусламж, хөнгөлөлт олгох, санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Ахмад настны хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх Эмнэлэг хяналтын комисс тогтоох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй ахмад настан нь Ахмад настны тухай хууль, эсхүл Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан ижил төрлийн тусламж, хөнгөлөлтөд хамрагдах тохиолдолд өөрийн сонгосон аль нэг тусламж, хөнгөлөлтөд хамрагдана.

1.3.Энэ журмын 1.2-т зааснаас бусад хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан комисс тогтооно.

Хоёр.Тусламж, хөнгөлөлтөд хамрагдах хүсэлт гаргах

2.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн энэ журамд заасан тусламж, хөнгөлөлтөд хамрагдах хүсэлтээ халамжийн нэгдсэн систем “ehalamj.mn” (цаашид “нэгдсэн систем” гэх)-ээр дамжуулан цахимаар, эсхүл сум, хорооны нийгмийн ажилтанд хандан цаасан хэлбэрээр гаргана.

2.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон сэтгэцийн эмгэгтэй хүний тусламж, хөнгөлөлтөд хамрагдах хүсэлтийг түүний эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч сум, хорооны нийгмийн ажилтанд гаргана.

2.3.Асрамж, халамжийн байгууллага, төрөлжсөн асрамжийн газарт асруулж байгаа, сэтгэцийн төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлж байгаа, хорих ангид ял эдэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тухайн байгууллагын нийгмийн ажилтан нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хандан тусламж, хөнгөлөлтөд хамруулах ажлыг хариуцна.



2.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүн тусламж, хөнгөлөлтөд хамрагдах хүсэлтийг сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхгүй.

Гурав.Тусламж, хөнгөлөлт олгоход үндэслэх бичиг баримт

3.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн энэ журамд заасан тусламж, хөнгөлөлтөд хамрагдах хүсэлт гаргахад шаардагдах өргөдөл, иргэний үнэмлэх, хүүхдийн төрсний гэрчилгээ болон шаардлагатай бусад мэдээллийг сум, хорооны нийгмийн ажилтан нэгдсэн системээс татан бүрдүүлнэ.

3.2.Сум, хорооны нийгмийн ажилтан хөгжлийн бэрхшээлтэй хүний хүсэлтийг хянан бүртгэж, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад илгээнэ.

3.3.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага сум, хорооны нийгмийн ажилтны илгээсэн хүсэлтийг хянан баталгаажуулна.

3.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авах мөнгөн тусламжийг жилд нэг удаа олгоход нэгдсэн системийн дараах бичиг баримтыг үндэслэнэ:

3.4.1.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс (цаашид “хүүхдийн комисс” гэх)-ын шийдвэр;

3.4.2.эрүүл мэндийн магадлалын зөвлөл, эсхүл Эмнэлэг хяналтын комиссын шийдвэр;

3.4.3.бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, дүлий, одой иргэн болохыг тодорхойлсон Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэр.

3.5.Ортопед, тусгай хэрэгслийг худалдан авсан үнийн хөнгөлөлтийг олгоход дараах бичиг баримтыг үндэслэнэ:

3.5.1.төрөлжсөн мэргэшлийн эмчийн дүгнэлт, хэрэв сумын эрүүл мэндийн төвд төрөлжсөн мэргэшлийн эмч байхгүй тохиолдолд сумын ерөнхий эмчийн дүгнэлт, хүүхдийн живхний хөнгөлөлт олгоход хүүхдийн комиссын шийдвэр;

3.5.2. ортопед, тусгай хэрэгслийн төлбөр төлсөн и-баримт, эсхүл нэхэмжлэх.

3.6. Протез, ортопед, тусгай хэрэгслийг дотоодод захиалгаар хийлгэсэн үнийн хөнгөлөлтийг олгоход дараах бичиг баримтыг үндэслэнэ:

3.6.1. төрөлжсөн мэргэшлийн эмчийн дүгнэлт, эсхүл протезын үйлдвэрээр хийлгэж байгаа тохиолдолд тухайн байгууллагын төрөлжсөн мэргэшлийн эмчийн нэгдсэн системд үүсгэсэн тодорхойлолт;

3.6.2. протез, ортопед, тусгай хэрэгслийн төлбөр төлсөн и-баримт, эсхүл нэхэмжлэх.

3.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүн (хүүхэд, насанд хүрэгсэд) болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг, сургуульд ирж, очих унааны зардлын хөнгөлөлтийг олгоход дараах бичиг баримтыг үндэслэнэ:

3.7.1. орон нутгаас аймгийн төв, эсхүл нийслэлд ирж суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн ирж, очих унааны зардал төлсөн баримт, хүүхдийн комиссын шийдвэр;

3.7.2. аймаг, нийслэл, сум, дүүргийн цэцэрлэг, сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хүний болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчид Засгийн газраас тогтоосон тусламж, хөнгөлөлтийн хэмжээний дагуу унааны зардлыг олгоход хүүхдийн комиссын шийдвэр.

3.8. Насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсголын хэл ярианы бэрхшээлтэй хүнд харилцаа холбооны зардлын хөнгөлөлтийг олгоход шаардлагатай тодорхойлолт Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрийг сум, хорооны нийгмийн ажилтан нэгдсэн системээс татаж бүрдүүлнэ.

Дөрөв. Тусламж, хөнгөлөлт олгох

4.1. Хүүхдийн комиссын шийдвэрийг үндэслэн байнгын асаргаа шаардлагатай өдөр тутам живх хэрэглэдэг 2-оос дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 3 жил тутам нэг удаа олгох живхний үнийн хөнгөлөлтийг Засгийн газраас тогтоосон жишиг үнэд багтаан гурав тэнцүү хувааж, жилд нэг удаа олгоно.



4.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүн протез, ортопед болон тусгай хэрэгслийг өөрийн сонгосон протезын үйлдвэр, холбогдох байгууллагаар хийлгэх, эсхүл ортопед, тусгай хэрэгслийг эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх байгууллага, эмийн сангаас авах тохиолдолд Засгийн газраас баталсан жагсаалт, жишиг үнийн дагуу хөнгөлөлтийг авна.

4.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын хэрэглэж байсан тэргэнцэр худалдан авсан тохиолдолд жишиг үнийн хөнгөлөлтийг 50 хувиар тооцон олгоно. Энэ тохиолдолд худалдан авах болон худалдах талуудын хүсэлт, тэргэнцэрийн фото зургийг сум, хорооны нийгмийн ажилтан нэгдсэн системд оруулж, тайлбар бичнэ.

4.4.Гадаад улсаас худалдан авсан, эсхүл хийлгэсэн протез, ортопед, тусгай хэрэгслийн төлбөрийн баримт болон хэрэглэж байгааг нотлох фото зургийг иргэнээс сум, хорооны нийгмийн ажилтан авч, нэгдсэн системд оруулан, тайлбар бичиж, Засгийн газраас тогтоосон жишиг үнийн дагуу олгоно.

4.5.Асрамж, халамжийн байгууллага, төрөлжсөн асрамжийн газар асруулж байгаа, эсхүл сэтгэцийн төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлж байгаа, хорих ангид ял эдэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнд протез, ортопед, тусгай хэрэгслийн үйлчилгээ үзүүлэх байгууллага явуулын хэлбэрээр, үйлчилж болно.

4.6.Аймаг, нийслэл, сум, дүүргийн цэцэрлэг, сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчид унааны зардлыг Засгийн газраас тогтоосон тусламж, хөнгөлөлтийн хэмжээгээр жилд нэг удаа иргэний банкн дахь харилцах дансанд шилжүүлнэ.

4.7.Хөдөө орон нутгаас аймгийн төв, нийслэлд очиж суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн ирж, очих унааны зардлын хөнгөлөлтийг тээврийн байгууллагын тогтоосон тарифт үнээр тооцон жилд нэг удаа иргэний банкн дахь харилцах дансанд шилжүүлнэ.

4.8.Энэ журмын 4.7-д заасан хөнгөлөлтийг олгохдоо хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч өөрийн унаагаар зорчсон тохиолдолд шатахууны баримтыг үндэслэн авто тээврийн тарифт үнээр тооцож олгоно.

4.9.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан унааны зардлын хөнгөлөлтийг олгохдоо өмчийн харьяалал харгалзахгүй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, коллеж, дээд сургууль, их сургуулийг хамруулна.

4.10.Энэ журмын 3.5, 3.6-д заасан хөнгөлөлтийг байгууллагын нэхэмжлэхээр авах тохиолдолд протез, ортопед, тусгай хэрэгсэл тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа тул байгууллага, иргэний банкн дахь харилцах дансанд мөнгө шилжүүлэхийг зөвшөөрсөн маягт (нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гаргасан)-ыг цахимаар, эсхүл цаасан хэлбэрээр бөглүүлнэ.

Тав.Төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох

5.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журамд заасан эмч, эмнэлгийн байгууллагын дүгнэлт, тодорхойлолт, шийдвэрийг төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан тухай бүр нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

5.2.Нэгдсэн системээс татах шаардлагатай бичиг баримтыг уг системд цонх үүсгэж байршуулна.

Зургаа.Бусад

6.1.Тусламж, хөнгөлөлт олгох үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтад нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тус тус хяналт тавьж ажиллана.

6.2.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын хяналт, шалгалт хариуцсан нэгж нь тусламж, хөнгөлөлтөд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүний бичиг баримтад хяналт тавьж ажиллана.

6.3.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалт хариуцсан нэгж хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөнгөлөлт, тусламж олгох үйл ажиллагаа, хууль, журам, чанар, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхэд түүврийн аргаар, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг хийнэ.

6.4.Энэ журамд заасан тусламж, хөнгөлөлтөд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний сэтгэл ханамжийн судалгааг цаасан болон цахим (киоск, мессеж) хэлбэрээр авч үнэлгээний системд бүртгэн, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага судалгааны үнэлгээг нэгтгэн, дүнг олон нийтэд ил тод мэдээлнэ.



6.5.Энэ журмын 6.4-т заасан судалгааны тайлан, дүнд үндэслэн нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага хариуцан үйлчилгээгээ сайжруулах арга хэмжээг зохион байгуулна.

6.6.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь тусгай дугаар бүхий нээлттэй утас, цахим хаяг тогтмол ажиллуулж, иргэний санал, гомдлыг цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэнэ.

6.7.Аж ахуйн нэгж, байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцээгүй, чанаргүй протез, ортопед, тусгай хэрэгсэл олгох, эсхүл олгоогүй боловч хуурамч баримт бүрдүүлж өгсөн бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.8.Тухайн хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэх, эсхүл байнгын асаргаа шаардлагатай эсэхийг буруу тодорхойлсон, шийдвэрийг хуурамчаар үйлдсэн, протез, ортопед, тусгай хэрэгсэл олгох дүгнэлтийг үндэслэлгүй гаргасан, тусламж, хөнгөлөлтийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.9.Тусламж, хөнгөлөлтөд хамрагдах хүнийг буруу тогтоосон, хуурамч бичиг баримт үйлдэн тусламж, хөнгөлөлт авсан хүн, хуулийн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэж, хохирлыг нөхөн төлүүлнэ.

---оОо---

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.25

Индекс: 200003